



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 99

Улаанбаатар хот

Албан журмын даатгагчдын холбооны
удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт
оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12¹.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн гишүүний үүрэгт ажлаас Б.Жаргал, Ж.Бат-Орших, Б.Нямаа нарыг чөлөөлж, Цагдаагийн ерөнхий газрын Нийгмийн хэв журам хамгаалах газрын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хэлтсийн дарга Ү.Зоригтбаатар, Сангийн яамны Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Н.Мандуул, “Ард даатгал” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Чулуунцэцэг нарыг тус холбооны удирдах зөвлөлийн гишүүнээр баталсугай.

2. Даатгалын тухай хууль тогтоомжийг чанд мөрдөж, хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг Ү.Зоригтбаатар, Н.Мандуул, Д.Чулуунцэцэг нарт үүрэг болгосугай.

3. Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

679000